

20 21 оны 4 сарын 30 өдөр

№ 1/2010

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦОГТБАЯР ТАНАА

Тухай бүр нийтэд мэдээлэх
мэдээлэл хүргүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 10.6-д “Үнэт цаас гаргагч нь хугацаат тайлагнал болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллээ энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу цахим болон цаасан хэлбэрээр Хороонд ирүүлж, өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд мэдээлэл хүргэх мэдээллийн журам”-ын 8.2-т “Үнэт цаас гаргагч нь тухай бүр ирүүлэх мэдээллийг Хорооны 225 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын дөрөвдүгээр хавсралтын дөрөв, Маягт 3-ын дагуу ирүүлнэ” гэж заасны дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1.3, Үнэт цаасны бүртгэлийн журмын дөрөвдүгээр хавсралтын 4.1.10-т заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг Маягт 3-ын дагуу гарган хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	ХасБанк РД: 2578697 Үнэт цаасны код: ХАС Утасны дугаар: 75771888
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Арилжааны банк
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Н.Мөнхцэлмэг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1.	Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцлийн талаар
	☒
2.	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанид аливаа захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэх талаар
	☒
3.	Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан гэрээ, хэлцлийн талаар
	☒
4.	Үнэт цаас гаргагчийн балансын гадуурх бүртгэлийн талаар
	☒
5.	Хөрөнгийн дахин үнэлгээний талаар
	☒
6.	Үнэт цаас гаргагч арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийн хэрэгжилтийн талаар
	☒
7.	Үнэт цаас гаргагчийн хараат бус нягтлан бодогчийн өөрчлөлтийн талаар

	х
8.	Өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан бол энэ талаар
	х
9.	Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл
	х
10.	Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл
	ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар Санжай Гүпта-г Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар, Майкл Мадден, Анджей Витак, Сюзанна Карр, Г.Цэвэгжав, Н.Цэлмүүн, Доминик Жак нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр тус тус томилсноос гадна Эми Чой, Нираж Вэдва, Б.Уламбаяр болон Стюарт Холл нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус Компанийн дүрмийн 8.16 хэсэгт заасны дагуу 2 жилийн хугацаатай томилов.
11.	Үнэт цаас гаргагчийн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар
	х
12.	Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээний талаар
	х
13.	Компанийн ёс зүйн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар
	х
14.	Шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрхийн талаар
	х
15.	Оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газрын талаар
	х
16.	Үйл ажиллагааны чиглэл, түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон эсэх талаар
	х
17.	Төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах шийдвэрийн талаар
	х
18.	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-д заасан мэдээлэл
	Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар ХасБанк ХК-ийн толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэж өөрчлөх байгуулах шийдвэрийг гаргав. Өөрчлөн байгуулах ажиллагааг хэрэгжүүлэх эсэх нь МонголБанк, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөс хамаарна.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

